



ШИНЖЭЭЧИЙН ТАЙЛАН

Байгууллагын нэр: Монгол улсын их сургууль
Шинжлэх ухааны сургууль

Сургалтын хөтөлбөрийн нэр: Математик

Индекс: D054101

Шинжээчийн баг:

Ахлагч: Ц.Лувсандорж

Гишүүд: Ч.Наранчимэг

Б.Баясгалан

2018.06.05

АГУУЛГА

Хуудас

Товчилсон үгийн тайлбар	4
I.Магадлан итгэмжлэх үйл явц, төлөвлөлт	4-5
II.Сургалтын хөтөлбөрийн танилцуулга	5
III.Мэргэжлийн зөвлөлийн тодорхойлолт	6-9
IV. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт	10-25
Шалгуур1:Хөтөлбөрийн төлөвлөлт.....	10-12
Шалгуур 2: Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл.....	12-14
Шалгуур 3:Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт.....	14-17
Шалгуур 4: Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа.....	18-19
Шалгуур 5:Багшийн үйл ажиллагаа.....	20-21
Шалгуур 6: Сургалтын үйл ажиллагаа.....	21-23
Шалгуур 7:Хөтөлбөрийн үр дүн, үр нөлөө.....	23-25
Шалгуур 8:Чанарын үнэлгээ, баталгаажилт.....	25
Дүгнэлт	26
Хавсралт	
I. Шинжээчдийн сургууль дээр ажилласан хуваарь.....	27
II. Ярилцлагад оролцсон оролцогчдын жагсаалт	
1. Багш нарын нэрс.....	28
2. Төгсөгчдийн нэрс.....	29
3. Ажил олгогчдын нэрс.....	30
4. Оюутны нэрс.....	31
III. Сургуулиас ирсэн албан бичиг	32
V.Мэргэжлийн зөвлөлийн шийдвэр	
VI. Магадлан итгэмжлэх комиссын шийдвэр	

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

1. МУИС-Монгол улсын их сургууль
2. БМИҮЗ-Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөл
3. БСШУСЯ-Боловсрол, Соёл, Шинжлэх ухаан, Спортын яам
4. ЮНЕСКО-Нэгдсэн Үндэстний Байгууллагын боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллага
5. БШУ-Боловсрол, шинжлэх ухаан
6. ЕШ-Ерөнхий шалгалт
7. ЭЭШ-Элсэлтийн ерөнхий шалгалт

I. МАГАДЛАН ШИНЖЛЭХ ҮЙЛ ЯВЦ, ТӨЛӨВЛӨЛТ

Сургуулийн нэр /Монгол, Англи/	МУИС, Шинжлэх ухааны сургууль National university of Mongolia	
Сургалтын хөтөлбөрийн нэр /Монгол, Англи/	Математик,	
Индекс	D054101	
Шинжээчид	Шинжээчдийн нэр, ажил, албан тушаал: Шинжээчийн багийн ахлагч: 1. Ц.Лувсандорж-Монгол улсын боловсролын их сургуулийн профессор. Шинжээчийн багийн гишүүд: 2. Ч.Наранчимэг-Санхүү, эдийн засгийн их сургуулийн профессор. 3. Б.Баясгалан-Олонлог сургуулийн зөвлөх.	
БМИҮЗ-ийн зохицуулагч	Б.Оюунчимэг	
Төлөвлөгөө	Он сар өдөр	Хийгдсэн байх ажлууд
	5/10	Ажлын албаны захирлын 2018-05-10 №58 тоот тушаалаар шинжээчийг томилсон.
	5/10	Шинжээчидтэй 2018-05-10 №19/18 тоот гэрээ хийсэн.
	5/10	Шинжээчдэд өөрийн үнэлгээний тайланг зохицуулагч хүлээлгэн өгсөн.
	5/21	Шинжээчид урьдчилсан үнэлгээний тайланг зохицуулагчид өгсөн.
	5/22	Зохицуулагч хөтөлбөрийн багтай хамтран бэлтгэл ажлыг хангуулсан.
	5/23-5/24	Сургууль дээр шинжээчид очиж ажилласан.
	6/05	Шинжээчид үнэлгээний тайланг зохицуулагчид хүлээлгэн өгсөн.
	6/07	Зохицуулагч шинжээчийн тайланг сургуульд илгээж санал авсан.

	6/15	Магадлан шинжилгээ хийхэд ашигласан өөрийн үнэлгээний тайлан, холбогдох бусад материалыг зохицуулагчид бүрэн хүлээлгэн өгсөн.
	6/18	Сургууль үнэлгээний тайлантай танилцаж, тайлбар, нотлох баримтыг зохицуулагчид хүлээлгэн өгсөн.
	6/25	Шинжээчид үнэлгээний тайланг эцэслэсэн.
Шалгуур шаардлага /журам/	БМИҮЗ-ийн 2014 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн 01 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралт БМИҮЗ-ийн дүрмийн 2.1-ийн “б” заалт, БМИҮЗ-ийн 2014 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн 01 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралт Боловсролын магадлан итгэмжлэх үйл ажиллагааны журмын 2.2.9-2.2.18 заалт, БМИҮЗ-ийн 2015 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн 05 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралт “Сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн шалгуур”,	

II. СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙН ТАНИЛЦУУЛГА

D054101 гэсэн индекстэй “Математик” мэргэжлийн бакалаврын сургалтын хөтөлбөр нь МУИС-иар 1942 оноос математикч бэлтгэсэн ирсэн үе үеийн хөтөлбөрийн өнөөгийн үргэлжлэл юм.

Энэхүү хөтөлбөрийг БСШУ-ны сайдын “Мэргэжлийн чиглэл, индекс шинэчлэн батлах тухай” 2014 оны 4 дүгээр сарын 1-ний өдрийн А/178 дугаар тушаал, “Нийтлэг шаардлага батлах тухай” 2014 оны А/174 тушаалыг тус тус хэрэгжүүлэхээр зорилгоор МУИС-ийн шинээр томъёологдсон алсын хараа, эрхэм зорилгод нийцүүлэн боловсруулсан байна.

“Математик” мэргэжлийн бакалаврын сургалтын хөтөлбөрөөр МУИС-иар Шинжлэх ухааны сургуулийн Байгалийн ухааны салбарын Математикийн тэнхим манай улсад математикийн бакалавр зэрэгтэй боловсон хүчин бэлтгэж байна.

III. МЭРГЭЖЛИЙН ЗӨВЛӨЛИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Мэргэжлийн зөвлөлөөс хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн өөрийн үнэлгээний тайланг хянан үзсэн тухай тэмдэглэл

2018.04.30

Мэргэжлийн зөвлөл

Байгалийн шинжлэх ухаан, математик, статистикийн чиглэлээр хөтөлбөрийн үнэлгээ хийх мэргэжлийн зөвлөл

Магадлан итгэмжлүүлэх хөтөлбөр

МУИС, Шинжлэх Ухааны Сургууль, Байгалийн Ухааны Сургууль, “Математик” D054101

Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний тайлан нь БМИҮЗ-ийн шаардлагын дагуу бичигдсэн. Нийт 130 хуудас, дагалдах 1 хавтас хавсралт бүхий материал байна. Мэргэжлийн зөвлөлөөс дараах дүгнэлт, зөвлөмжийг гаргаж байна. Үүнд:

Шалгуур 1: Хөтөлбөрийн төлөвлөлт

Шалгуурт тавьсан шаардлагын дагуу зохих баримт нотолгоонд үндэслэн нилээн дэлгэрэнгүй бичигдсэн байх бөгөөд багш бүрийн оролцоог хангаж өөрийн үнэлгээг гаргасан байна.

Зөвлөмж, анхаарах зүйл:

- SWOT шинжилгээний давуу талд тусгагдсан нэг оюутанд ногдох багш нарын тоо тодорхойгүй (35-р хуудас) байгааг тодорхой болгох
- Цаашдын зорилгод тусгагдсан “төгсөгчдийн судалгааг тогтмолжуулах, ажлын байрны судалгааг нарийвчлан хийх” зорилгын хүрээнд ямар давтамжтайгаар ямар хугацаанд ямар аргаар тулгуурлан хэрхэн хийх талаар тодорхой тусгах
- Оюутны эзэмшиж буй ямар чадварт, ямар аргаар хэрхэн яаж дүн шинжилгээ хийх, үр дүнгээ хэрхэн хэмжих талаар тодорхой тусгах

Шалгуур 2: Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл

Шалгуурт тавьсан шаардлагын дагуу зохих баримт нотолгоонд үндэслэн бичигдсэн байна. Тус хөтөлбөр нь МУИС-ийн ШУС-ийн Байгалийн Ухааны Салбарт хамаардаг бөгөөд тусгайлан зориулсан анги, танхим, лаборатори гэж байдаггүй бөгөөд сургалтын нэгдсэн албанаас оноосон хуваарьт анги танхим, лабораторийг ашигладаг байна. Багш бүрийн оролцоог хангаж тухайн шалгуурын өөрийн үнэлгээг гаргасан байна.

Зөвлөмж, анхаарах зүйл:

- Цаашдын зорилгод тусгагдсан мэргэшүүлэх хичээлд хэрэглэгдэх олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн өргөн хэрэглэгддэг ном сурах бичгийн жагсаалтыг гаргаж, орчуулах ажил ямар цаг хугацаанд явагдах болон хэдий хэмжээний санхүүжилт шаардагдахыг тодорхойлох
- Албан ёсны эрхтэйгээр хяналдан авах компьютерийн программ хангамжийн жагсаалтыг гаргах

Шалгуур 3: Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

Шалгуурт тавьсан шаардлагын дагуу тодорхой баримт нотолгоонд үндэслэн нилээн дэлгэрэнгүй бичигдсэн байх бөгөөд багш бүрийн оролцоог хангаж өөрийн үнэлгээг гаргасан байна.

Зөвлөмж, анхаарах зүйл:

- SWOT шинжилгээ хийгдээгүй. Гэхдээ цаашид анхаарах, сайжруулах зүйлүүд нилээдгүй тусгагдсан байгаа нь сайшаалтай. Эдгээрийг бодит ажил хэрэг болгох талаар анхаарч ажиллахыг зөвлөж байна. Ялангуяа шаардлагатай санхүүжилтийг эртнээс төлөвлөн сургуулийнхаа төсөвт суулгах талаар анхаарах хэрэгтэй.

Шалгуур 4: Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа

Шалгуурт тавьсан шаардлагын дагуу бичигдсэн байх бөгөөд багш бүрийн оролцоог хангаж өөрийн үнэлгээг гаргасан байна.

Зөвлөмж, анхаарах зүйл:

- SWOT шинжилгээ хийгдээгүй байна. Иймд тус шинжилгээг хийх шаардлагатай.

Шалгуур 5: Багшийн үйл ажиллагаа

Шалгуурт тавьсан шаардлагын дагуу баримт нотолгоонд үндэслэн нилээн дэлгэрэнгүй бичигдсэн байх бөгөөд багш бүрийн оролцоог хангаж өөрийн үнэлгээг гаргасан байна. Маш сайн чадварлаг боловсон хүчинтэй.

Зөвлөмж, анхаарах зүйл:

- SWOT шинжилгээ хийгдээгүй байна.
- 92, 98-р хуудаст тусгагдсан зүйлээс өөр цаашид анхаарах, сайжруулах зүйлүүд байхгүй байна. Иймд мэргэжлийн онцлогт тохирсон багшийн хөгжлийн хөтөлбөр, судалгаанд суурилсан сургалтын тогтолцоог бий болгоход чиглэсэн зүйлүүдийг оруулж өгөх

Шалгуур 6: Сургалтын үйл ажиллагаа

Шалгуурт тавьсан шаардлагын дагуу баримт нотолгоонд үндэслэн бичигдсэн байх бөгөөд багш бүрийн оролцоог хангаж өөрийн үнэлгээг гаргасан байна.

Зөвлөмж, анхаарах зүйл:

- SWOT шинжилгээ хийгдээгүй байна.
- Хичээл бүрийн хувьд “Гарц үр дүнгийн шинжилгээ”-г хийж, сургалтын үйл ажиллагааг сайжруулдаг, хөгжүүлдэг системийг бүрдүүлэх талаар анхаарахыг зөвлөж байна.

Шалгуур 7: Хөтөлбөрийн үр дүн, үр нөлөө

Шалгуурт тавьсан шаардлагын дагуу бичихийг зорисон хэдий ч маш товч бичигдсэн байх бөгөөд өөрийн үнэлгээ тодорхойгүй байна.

Зөвлөмж, анхаарах зүйл:

- SWOT шинжилгээ хийгдээгүй байна.
- Төгсөгч, ажил олгогчийн судалгааг тогтмолжуулах, үр дүнг үйл ажиллагаандаа тусгах талаар анхаарахыг зөвлөж байна.

Шалгуур 8: Чанарын үнэлгээ, баталгаажуулалт

Шалгуурт тавьсан шаардлагын дагуу маш товч бичигдсэн байх бөгөөд өөрийн үнэлгээ тодорхойгүй байна.

Зөвлөмж, анхаарах зүйл:


- SWOT шинжилгээ хийгдээгүй байна.
- Сургуулийн дотоод чанарын баталгаажилт хариуцсан алба нэгжтэй нягт уялдаа холбоотой, хамтран ажиллах

Дүгнэлт

- Тус хөтөлбөрийн өөрийн үнэлгээний тайлан БМИҮЗ-ийн шаардлагын дагуу бичигдсэн байна.
- Шалгуур 1-6 дээр өөрийн үнэлгээ хийгдсэн.
- Шалгуур 7, 8 дээрх өөрийн үнэлгээг тодруулах шаардлагатай.
- Тайланд үг үсгийн алдаа багагүй байгааг анхаарах, засах. Мөн утга найруулгыг анхаарах, сайжруулах.

Тайланг хянан үзсэн

Байгалийн шинжлэх ухаан, математик, статистикийн чиглэлээр хөтөлбөрийн үнэлгээ хийх мэргэжлийн зөвлөлийн гишүүн



Ч.Наранчимэг (утас 99086564, e-mail: naranchimeg.ch@ufe.edu.mn)

МУИС “Математик” хөтөлбөрийн Магадлан итгэмжлэлийн өөрийн үнэлгээний тайланд мэргэжлийн зөвлөлөөс өгсөн зөвлөмжийн дагуу хийсэн сайжруулалтын талаар

2018.05.07

Шалгуур 1

1. SWOT шинжилгээний давуу талд тусгагдсан нэг оюутанд ноогдох багшийн тоог тодорхой болгох гэсэн зөвлөмжийг тусгасан. Үүнийг авч үзэхдээ нэг багшид ноогдох багшийн тоог сүүлийн 5 жилийн байдлаар харуулсан
2. Цаашдын зорилгод тусгасан “Төгсөгчийн судалгааг тогтмолжуулах” зорилгын хүрээнд давтамж болон арга зүйг тусгасан.
3. Мэдлэг чадварыг хэрхэн үнэлэх талаар тодорхой хэмжээнд дэлгэрүүлсэн.

Шалгуур 2

1. Мэргэжлийн хичээлүүдэд ашиглаж байгаа ашиглаж болох монгол хэл дээрх ном сурах бичиг байгаа эсэх, хадгалагдаж буй хэлбэрийн жагсаалтыг гаргаж, Хавсралт 24-т оруулж өгсөн.
2. Яг одоогийн байдлаар ашиглагдах програм хангамжийг тусгасан.

Шалгуур 3

1. SWOT шинжилгээг хийсэн.

Шалгуур 4

1. SWOT шинжилгээг хийсэн.

Шалгуур 5

1. SWOT шинжилгээг хийсэн.

Шалгуур 6

1. SWOT шинжилгээг хийсэн.

Шалгуур 7

1. SWOT шинжилгээг хийсэн.

Шалгуур 8

1. SWOT шинжилгээг хийсэн.

Дүгнэлт хэсэгтэй холбоотой

1. Шалгуур 7 ба 8 дээр өөрийн үнэлгээг хийсэн.
2. Үг үсгийн алдааг spell check программ ашиглан хийсэн. Зарим утга найруулгын алдааг зассан.

алдааг зассан.

Тэнхимийн эрхлэгч:*Д.Пүрэвсүрэн*.....Д.Пүрэвсүрэн/

IV. ШИНЖЭЭЧИЙН ҮНЭЛГЭЭ, ДҮГНЭЛТ

ШАЛГУУР 1. ХӨТӨЛБӨРИЙН ТӨЛӨВЛӨЛТ

Оролцогч болон сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэсэн, үйл ажиллагааны төлөвлөлт, зохицуулалтын цогц баримт бичгийг нийтлэг шаардлагын дагуу иж бүрэн боловсруулан баталгаажуулж, тогтмол сайжруулдаг байна.

1.1 Хөтөлбөрийн хэрэгцээ, шаардлага

Хөтөлбөр нь үндэсний болон олон улсын боловсролын чиг хандлагыг баримжаалан, сургалтад оролцогч болон сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэн боловсруулагдсан байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Нийгэм, эдийн засаг, технологи, салбарын хөгжлийн ирээдүйн төлөв, сонирхогч талуудын эрэлт хэрэгцээнд дүн шинжилгээ хийсэн байдал
- Төгсөгчийн /мэргэжилтний/ загвар
- Хөтөлбөрийг индексийн хувьд ижил салбар, чиглэлийн гадаад дотоодын хөтөлбөрүүдтэй харьцуулсан байдал /ялгаатай, давуу, сул тал, сайжруулалт/

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

- Математикийн бакалавр зэрэгтэй төгсөгчийн эрэлт хэрэгцээ, ирээдүйн төлөв байдлыг хөтөлбөрийн хэмжээнд хангалттай тусгажээ. Математикийн бакалавр зэрэгтэй төгсөгч нийгмийн аль ч салбар, мэргэжил рүү хөрвөх боломжийг хангах нь цаашид энэ хөтөлбөрийн амьдрах чадвар, хэрэгцээт байдлыг улам нэмэгдүүлэх юм.
- Төгсөгчийн мэргэжлийн загварын хувьд одоо бий болсон нөхцөл байдал, хууль-эрхзүйн орчны хувьд хангалттай болсон байна. Математикийн бакалавр зэргийг авсны дараа төгсөгч ажил хөдөлмөр эрхлэхийн тулд ямар нэг мэргэжлийн оноосон нэргүй байгаа нь хөтөлбөрийн гадаад үнэлэмжийг илт доошлуулж байна. Судлаач-математикийн бакалавр гэсэн илүү тодорхой хувилбарыг бий болгох нэн шаардлагатай байна.
- Хөтөлбөрийн индекс нь ЮНЕСКО-ийн 2011 оны ангилал болон БШУ-ны сайдын 2014 оны А/78 тушаалаар тогтоосон ангиллыг илт зөрчсөн байна. Математик, статистик гэсэн бие даасан хөтөлбөрийн индексийг хүчээр Байгалийн ухааны ангилалд хамааруулж, математикаас хэрэглээний хэсгийг салгасан нь өнгөцхөн, буруу хийсэн явдал болжээ. МУИС-аас өөр математикийн бакалавр бэлддэг үндэсний сургуулиуд байхгүй учир харьцуулалт хийгдэх боломжгүй юм. Математикийн бакалавр хөтөлбөрөөр сурахыг хүсэгч ерөнхий суурь хичээлийн 36 кредит цагийг нийгэм, хүмүүнлэгийн ухааны элсэгчидтэй хамт бүтэн 2 жил үзэж байгаа нь Математик хөтөлбөрийг хэрэгжүүлэх оновчтой боломжийг олгохгүй байгаа нь харамсалтай. 3,4-р хичээлийн жилдээ математикийн үндсэн суурь, мэргэжлийн хичээлүүдийг нэг дор олноор үзэхээр зохиогдсон нь хөтөлбөрийн алдаа гэхээсээ илүү МУИС-д хийгдсэн бүтцийн том алдаа болжээ. Иймд хөтөлбөр 2014 оноос өмнө байсан хөтөлбөрөөс дордсон, хөтөлбөрийн индексийн хувьд будилсан, зах зээлд эрэлттэй байгаа математик мэргэжлийн хэрэгцээг хангахааргүй сул болжээ.
- Математик хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлэхийн тулд ЮНЕСКО, Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас

гаргасан ангилал, тушаал шийдвэрийг гуйвуулж, сааруулалгүйгээр үнэнчээр хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Зөвлөмж:

- МУИС-ийн Математик хөтөлбөртэй холбоотой салбар сургуулиудын бүтэц, хөтөлбөрийн ангиллыг яаралтай өөрчлөн Математик, статистикийн хөтөлбөрийг олон улсын жишгийн дагуу хэрэгжүүлэх нөхцөл бололцоог бий болгох шаардлагатай.

1.2 Хөтөлбөрийн үзэл баримтлал, зорилго

Хөтөлбөрийн үзэл баримтлал тодорхой; төгсөгчийн эзэмшсэн байх мэдлэг, ур чадвар, хандлага нь мэргэжлийн салбарын хөгжил, зах зээлийн эрэлтэд нийцсэн байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд баримталж байгаа үзэл баримтлал, сургалтын арга зүй, тогтсон үнэлгээний систем
- Хөтөлбөрийн хүрэх үр дүн, онцлог, сургуулийн эрхэм зорилго, зорилттой нийцсэн байдал
- Төгсөгчийн эзэмших мэдлэг, ур чадвар, хандлагыг тодорхойлоход оролцогч, сонирхогч талуудын саналыг тусгаж, хөтөлбөр боловсруулах ажлын хэсэгт төлөөллийг оролцуулсан байдал

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

- Математик хөтөлбөрийн үзэл баримтлал, сургалтын арга зүй, үнэлгээний тогтолцоо нь МУИС-д одоо байгаа бүтэц, эрхзүйн орчны хувьд хангалттай боловсрогджээ.
- Хөтөлбөрийг хэрэгжүүлж чадвал хүрэх үр дүн, хэрэгцээт байдлын онцлог нь сургуулийн эрхэм зорилго, зорилттой нийцэж чадахаар байна.
- Хөтөлбөрийг боловсруулахдаа оролцогч, сонирхогч талуудын саналыг хангалттай тусгаж чадсан байна.

Онцлог зүйл/Туршлага:

- МУИС-ийн өнөөгийн бүтэц, хөтөлбөрүүдийн индекс, сургалтын төлөвлөгөөний зохион байгуулалт нь математикийн онолын чиглэлийн мэргэжилтэнг бэлтгэх ямар ч нөхцлийг хангаагүй байхад энэхүү хөтөлбөр боловсрогдож хэрэгжиж эхэлсэн нь үнэхээр онцлог болжээ.

Анхаарах асуудал:

- Үзэл баримтлалыг эргэж харах, математикч бэлтгэх урьдчилсан нөхцлүүд төдийгүй математикийн бакалавр зэрэгтэй судлаачид багш, хэрэглээ, нийгмийн ухааны салбарууд руу хөрвөх нөхцлийг тусгасан уян хатан боломжуудыг бий болгох шаардлагатай байна.

Зөвлөмж:

- Математик хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлэхийн тулд сургалтын төлөвлөгөөг энэ хөтөлбөрт зохицуулан өөрчлөх шаардлагатай юм. Ерөнхий суурь хичээлийн багцыг 4 жилийн хугацаанд хэзээ ч үзэж болохоор зохицуулж, мэргэжлийн болон сонгон судлах хичээлүүдийг эрт сонгох боломжоор хангах ёстой.

1.3 Хөтөлбөрийн төлөвлөлтийн баримт бичгүүд

Сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөр нь тухайн хөтөлбөрөөр суралцагчид олгох мэдлэг, ур чадвар, хандлагын агуулга; сургалтын үр дүнд чиглэсэн арга зүй; сургалтын үнэлгээний оновчтой хэлбэрийг бүрэн багтааж, оролцогч болон сонирхогч талуудын санал зөвлөмжийг тогтмол тусган сайжруулдаг байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Хөтөлбөрт тавигдах нийтлэг шаардлагыг хангаж, баталгаажуулсан байдал
- Сургалтын төлөвлөлт нь онол, практикийг зохистой хослуулсан, суралцагчийн мэргэжлийн болон хувь хүний ур чадваруудыг хөгжүүлэхэд чиглэсэн байдал
- Хичээлийн хөтөлбөр нь хөтөлбөрийн үр дүнд чиглэсэн, агуулга, ур чадварын хувьд харилцан залгамж холбоотой, сургалтын арга зүйн болон үнэлгээний олон талт арга, хэлбэрийг тусгасан байдал

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

- Хөтөлбөрт тавигдах нийтлэг шаардлагыг сайн хангасан байна.
- Сургалтын төлөвлөлт нь онол, практикийг зохистой хослуулсан, суралцагчийн мэргэжлийн болон хувь хүний ур чадваруудыг хөгжүүлэхэд хангалттай чиглэсэн байна.
- Хичээлийн хөтөлбөр нь хөтөлбөрийн үр дүнд чиглэсэн, агуулга, ур чадварын хувьд харилцан залгамж холбоотой, сургалтын арга зүйн болон үнэлгээний олон талт арга, хэлбэрийг тусгаж чаджээ.

Онцлог зүйл/Туршлага:

- Математикийн тэнхимд ажиллаж байгаа үндэсний ммэргэжилтнүүдийн ур чадвар, мэдлэгт түшиглэсэн нь онцлог давуу тал байна.

Анхаарах асуудал:

- Математик хөтөлбөрийг зөв, оновчтой хэрэгжүүлэхгүй аваас Монгол улс үндэсний математикчдаа өөрсдөө бэлддэг уламжлалаа алдах бөгөөд буцааж сэргээхэд асар их хугацаа, хөрөнгө мөнгийг зарцуулах болно.

Зөвлөмж:

- Математик хөтөлбөрийн хүрээнд онолын математикийг шууд үзэх сонирхолтой суралцагчдад зориулсан, ерөнхий суурь хичээлийн багцыг хэзээ ч үзэж болохоор тусгай сургалтын төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлэх шаардлагатай байна. Өнөөдөр МУИС-д байгаа бүтцийн хүрээнд ийм уян хатан байдлыг бий болгох нь үндэсний математикчдаа бэлтгэх эрхэм үүргийг хэрэгжүүлэх үндсэн гарц гэж харагдаж байна.

1-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

ШАЛГУУР 2. ХӨТӨЛБӨР ХЭРЭГЖҮҮЛЭХ ОРЧИН, ТЕХНОЛОГИЙН НӨХЦӨЛ

Хөтөлбөрийн зорилго, зорилтыг үр дүнтэй хэрэгжүүлэх, амжилттай суралцахад дэмжлэг үзүүлэхүйц шаардлагатай нөөцийг бүрдүүлсэн эсэхэд дүгнэлт хийх

2.1 Сургалтын орчин

Сургалт, судалгаа явуулах анги танхим, лаборатори, урлан, багаж хэрэгсэл, багшийн ажиллах орчин нь хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэх шаардлага хангасан, стандартад нийцсэн шинэчлэл хийдэг байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Эрүүл, аюулгүй, тохилог орчинг бүрдүүлсэн байдал
- Тоног төхөөрөмж, мэдээллийн технологийн хэрэгсэл, лаборатори, урлангийн хангалт, ашиглалтын байдал
- Бие даан болон багаар ажиллах орчны хангалт

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

- Математикийн хичээлийг заах орчин хангалтгүй, самбар, анги танхимийн тохижилт тааруу байдал ажиглагдлаа. Багш, эрдэмтний өрөө тасалгааны хангамж, семинар, уулзалтын тусгай өрөөнүүд байхгүй байгаа нь хөтөлбөрийн хэрэгжилтийг муутгах том шалтгаан болж байна.

Анхаарах асуудал:

- Багш оюутанд зөвлөгөө өгөх танхим, математикийн семинар, оюутны бие даан ажиллах тогтмол өрөө, танхимыг бий болгох шаардлагатай байна. Сургалтын хийгээд багш нарын өрөө, тасалгааг орчны эрүүл ахуйн шаардлагын дагуу сайжруулах.

Зөвлөмж:

- Улс орны уураг тархи нь тэр улсын математикчид байдаг. Математик, математикчидгүйгээр тэргүүлж хөгжсөн улс орон хаана ч байдаггүй. Тусгаар тогтнол ч байхгүй болдог. Бидний өмнөөс харь улсууд бодлого төлөвлөж, юу хийх, яаж амьдрахыг зааж эхэлдэг жамтай. Математикчдад олон зүйл хэрэггүй байдаг. МУИС-ийн хувьд халтар ч гэсэн хэдэн математикчдаа дээдлэн илүү тохилог орчин нөхцлөөр хангах нь ядаад нэр төрийн хэрэг болох юм.
- МУИС-ийн үнэт зүйл, бахархлын нэг болох математикийн нэг хөтөлбөрийг хэрэгжүүлэх орчин, нөхцлийг сайжруулах, санхүүжилтийг манай улсын төрөөс болон МУИС-аас онцгой анхаарал тавибал зохино.

2.2 Сургалтын хэрэглэгдэхүүн, хэрэгсэл

Хөтөлбөрийн онцлогоос хамааран зайлшгүй шаардлагатай сургалт, судалгааны программ хангамж, хичээлийн хэрэгсэл, материаллаг нөөцөөр хангадаг байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Программ хангамж, симуляци, виртуал лабораторийн хэрэглээ, хүртээмж
- Хичээл практикийн материаллаг нөөц, хэвлэмэл үзүүлэн, тараах материал, хэрэглэгдэхүүний хүртээмж, хэрэглээ
- Сургалтын ажлыг зохион байгуулах заавар, удирдамж, зөвлөмжийн хүртээмж

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

- Сургалтыг удирдан зохион байгуулах үйл ажиллагаа журамлах МУИС-ийн захирлын тушаалаар батлан мөрдөж байгаа.
- Сургалт явуулах үйл ажиллагааг хөнгөвчлөх цахим орчин, дэд бүтэц (СиСи)-ийг бий болгон, түүний үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангасан.

Онцлог зүйл/Туршлага:

- Сургалтын үйл ажиллагааг хөнгөвчлөх нэгэн дэд бүтэц болох СиСи тогтолцоог бий болгон, үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангасан.

2.3 Номын сан, мэдээллийн эх үүсвэр

Багш, суралцагчдын сургалтын үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхүйц хэрэгцээт мэдээллээр тогтмол, чанартай хангадаг байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Үндсэн сурах бичиг, гарын авлага, эрдэм шинжилгээний сэтгүүлийн судалгаа, хүртээмж, хэрэглээ
- Виртуал, дижитал видео, аудио болон бусад цахим эх үүсвэрүүдийн байдал
- Цахим орчны хүртээмж, хэрэглээ
- Сургалт, судалгааны лицензтэй программын ашиглалтын байдал

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

- МУИС тохилог номын сантай болсон нь ямар ч хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлэх таатай нөхцөл юм.

Онцлог зүйл/Туршлага:

- МУИС-ийн номын сан нь богино хугацаанд бий болгосон сайн туршлага юм.

Анхаарах асуудал:

- Цэвэрхэн, тохитой байдлаа урт хугацаанд хадгалах менежментийг бий болгоход анхаарах шаардлагатай.

Зөвлөмж:

- Дэлхийн том номын сангуудтай холбогдож онлайн төдийгүй, цахим номын санг бүрдүүлж, санг баяжуулбал зохино.

2-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан**ШАЛГУУР 3. ХӨТӨЛБӨРИЙН УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ**

Хөтөлбөрийн удирдлага нь сургуулийн алсын хараа, эрхэм зорилгод нийцүүлэн сургалтын үйл ажиллагааг чанартай, тасралтгүй явуулахад нөөцийг оновчтой хуваарилж; хөдөлмөрлөх, суралцах таатай орчинг бүрдүүлэн хөтөлбөрийн хөгжлийг хангахуйц стратеги, менежментийг хэрэгжүүлнэ.

3.1 Хөтөлбөрийн удирдлагын үйл ажиллагаа

Хөтөлбөрийн удирдлагын үйлчилгээ нь сургалтын чанарыг сайжруулахад чиглэж, нийгмийн хариуцлагатай, оролцогч болон сонирхогч талуудын оролцоог хангадаг байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Сургалтын удирдлага, мэдээллийн системийн ашиглалт, хяналт, ил тод байдал
- Хөтөлбөрийн нэгжийн /тэнхим, профессорын баг, хөтөлбөрийн хороо/ шийдвэр гаргалт, хэрэгжилтийн үнэлгээнд багш, суралцагчдын оролцоог нээлттэй, ил тод хангасан байдал
- Хөтөлбөрийг боловсруулах, хэрэгжүүлэх, үнэлэхэд шаардлагатай дүрэм, журмуудын хэрэгжилт
- Урт болон богино хугацааны төлөвлөлт, гүйцэтгэлийн тайлан, ахиц өөрчлөлтийн дүн шинжилгээ механизм
- Санал, гомдол хүлээн авах, хариу өгөх үйл ажиллагаа, систем бүрдсэн байна.

- Хөтөлбөрийн багш, ажилтнуудын хүний нөөцийн судалгаа, шинжилгээ, хөгжүүлэх ажлын үнэлгээ, гүйцэтгэлийн болон үр дүнгийн урамшууллын хэрэгжилт

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

- “Математик” мэргэжлийн хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт нь МУИС, ШУС-ийн эрхэм зорилгыг хэрэгжүүлэхэд бүрэн чиглэсэн байна.
- Хөтөлбөрийг хэрэгжүүлэх чадварлаг багшлах боловсон хүчин, хүний нөөц бий болсон.
- Хөтөлбөрийг хэрэгжихийн үндсэн нэгж ажил болох хичээл, сургалтыг явуулдаг мэргэжлийн онцлогтой арга зүй, технологи бий болсон.
- Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах сургалтын цаасан болон цахим хэрэглэгдэхүүн, сурах бичиг, гарын авлагын уламжлал, шинэчлэлийг хослуулсан цогц бүрдэл бий болсон.
- Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалтыг хөнгөвчлөх зориулалттай сургалтыг удирдах тогтолцоо (СиСи)-г бий болгож, үйл ажиллагааг нь тогтворжуулсан.
- Профессорт суурилсан их сургуулийн хөгжлийн чиг хандлага, санхүүгийн дэмжлэг бий болсон.

Анхаарах асуудал:

- МУИС, ШУС-ийн “...либерал арт уламжлалд суурилсан хөтөлбөртэй байх...” гэсэн тодотголтой алсын хараа нь “математик”-ийн мэргэжлийн хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалтад дор дурдсан зохиомол бэрхшээлийг үүсгэж байна. Үүнд:
 - Математик мэргэжлээр элссэн оюутан эхний улирлаас эхлэн математикийн хичээлийг үздэггүй нь бодит байдал болсон.
 - Либерал арт хандлагад баримжаалсан сургалтын төлөвлөгөөгөөр суралцагч сүүлийн улиралд хэт ачаалалтайгаар суралцах бодит зохисгүй байдал, нөхцөл бий болсон.
 - Либерал арт хандлагад баримжаалсан сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг дүүргэсний дараа суралцагч мэргэжил эзэмшээгүй юм шиг байдал хүрч байна. Өөрөөр хэлбэл, төгсөгчдөд олгох баримт бичигт албан ёсны индекс бүхий мэргэжлийн нэр бичиж болохгүй байгаа байдал бий болсон.

Зөвлөмж:

- “...либерал арт уламжлалд суурилсан хөтөлбөртэй байх...” гэдэг нь их сургуулийн алсын хараа болох нь хэр зохимжтой нягтлан үзэх,
- Хөтөлбөрийн хөгжлийн либерал арт уламжлал нь “математикт суралцах, мэргэжих, мэргэших үйлийн онцлогтой нийцэл, тохироц эсэхийг тогтоох,
- Математикийн бакалаврын хөтөлбөрийг өөрийн орны өвөрмөц нөхцлийг харгалзан мэргэжлийн онцлогтойгоор уламжлалд тулгуурлан шинэчлэн хөгжүүлэх, хэрэгжүүлэх.

3.2 Хөтөлбөрийн маркетингийн идэвхжүүлэлт

Хөтөлбөр нь тогтвортой байдлаа хангахуйц идэвхжүүлэлтийн хөтөлбөр, төлөвлөгөөтэй байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Хөдөлмөрийн зах зээлийн тандан судалгааны давтамж

- Хөтөлбөрийн сурталчилгаа, идэвхжүүлэлтийн арга хэлбэр, хүртээмж, үр нөлөө

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

- Математикийн бакалаврын зэрэг олгох сургалтын хөтөлбөр хэрэгжүүлэх өвөрмөц онцлог бүхий нийгмийн хэрэгцээ, хөдөлмөрийн зах зээлийг бүтээж чадсан. Төгсөгчдийн 45 дээш хувь богино хугацаанд ажлын байраар хангагддаг. Математикийн гүнзгийрүүлсэн сургалттай төрийн болон төрийн бус өмчийн сургуульд математикийн багшаар ихэнхи төгсөгчдөд ажилладаг. Тус сургуулийн математикийн олимпиадыг зохион явуулахад идэвхитэй оролцох уламжлалт байдал нь хөдөлмөрийн өөрийн онцлогтой өвөрмөц зах зээлийг бий болгоход нөлөөлсөн.

Зөвлөмж:

- Математикийн бакалаврын зэргийн хөтөлбөрөөр суралцан төгсөгчид ажиллаж болох ажлын байрны ерөнхий зураглал, жагсаалтыг бий болгох чиглэлээр судалгаа хийвэл зохино.

3.3 Төгсөлтийн дараах бодлого

Хөтөлбөр нь төгсөгчидтэйгээ байнгын эргэх холбоотой, тэдний мэргэжлийг дээшлүүлэхэд чиглэсэн сургалт зохион байгуулж, төгсөгчид нь суралцаж буй суралцагчдад мэргэжлийн чиглэлээр ажиллахад нь зөвлөн тусладаг байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Төгсөгчдийн карьерын өсөлтийн судалгаа
- Үргэлжлүүлэн суралцагчдын хувь хэмжээ
- Төгсөгчдийг давтан сургалтад хамруулах бодлого, төлөвлөгөө, хамрагдсан байдал
- Төгсөгчдийн холбооны үйл ажиллагааны тогтмолжсон байдал

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

- Төгсөгчийн карьерын өсөлтийн судалгааг явуулдаг. Үргэлжлүүлэх суралцагчдын хувь 14%. Төгсөгчидтэйгээ ажиллах эргэх холбоог бий болгож байна.

3.4 Олон улсын харилцаа, хамтын ажиллагаа

Олон улсын их дээд сургуулиуд, судалгааны болон мэргэжлийн байгууллагуудтай холбоо тогтоож; багш, суралцагч солилцоо, тэтгэлэгт ба хамтарсан хөтөлбөр, сургалт, судалгаа, семинар зэрэг хэлбэрээр хамтран ажилладаг байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Хэрэгжүүлж буй хамтарсан төсөл, хөтөлбөрүүдийн тайлан, дүгнэлт
- Багш, суралцагч солилцоо, тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдагсдын тоо
- Олон улсын хурал семинар, судалгаа болон бусад арга хэмжээнд оролцсон тоо, үр дүн, ач холбогдол

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Өөрийн үнэлгээний тайланд дурдагдсан баримт нь шинжээчийн ажиглалтаар нотлогдсон (Өөрийн үнэлгээний тайлан, 71-72 хуудас).

3.5 Дотоод хамтын ажиллагаа, нийгэмд үзүүлэх үйлчилгээ

Хөтөлбөр хэрэгжүүлэгч нь мэргэжлийн холбоод, үйлдвэр, үйлчилгээний байгууллагууд, ажил олгогч эздийн холбоо, төрийн болон ТББ-уудтай хамтран ажилладаг байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Хамтран ажиллах гэрээ, хэлцэл, ажлын үр дүн
- Хэрэгжүүлж буй ажлуудын тайлан, дүгнэлт
- Хамтын ажиллагааны арга, туршлага
- Нийгэмд үзүүлсэн үйлчилгээний хэлбэр, хамрагдагсдын тоо үр дүн /багш, суралцагчдын зүгээс/

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

- Өөрийн үнэлгээнд дурдагдсан үзүүлэлт, нотолгоо шинжээчийн ажиглалтаар нотлогдсон. (Өөрийн үнэлгээний тайлан, 74-75)

3.6 Санхүүжилт

Хөтөлбөрийн санхүүжилтийн тодорхой хувь нь багш, суралцагчийн хөгжилд зарцуулагддаг, олон эх үүсвэртэй байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Төсөв, санхүүгийн бие даасан байдлын хөгжил
- Нэг суралцагчид ноогдох өртөг зардлын тооцоо
- Хөтөлбөрийн хүрэх үр дүнд чиглэгдсэн шинэчлэлт, өөрчлөлтөд зориулсан төсөв
- Төр хувийн хэвшлийн дэмжлэг, санхүү түүний зарцуулалт
- Төсвийн уламжлалт бус эх үүсвэр, бүрдүүлэлт, хуваарилалт, санхүүжилт

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

- Математикийн бакалаврын зэргийн хөтөлбөрөөр хичээллэж буй суралцагчдад чиглэсэн багшлах, судлах, дэмжих, үнэлэх, багш нарын мэргэжлийг дээшлүүлэх зэрэг үндсэн үйл ажиллагааг өртөгжүүлж төлөвлөх хэрэгжүүлэх хандлага бий болсон.

Анхаарах асуудал:

- Математикийн бакалаврын хөтөлбөр цаашид өөрөө өөрийгөө бүрэн санхүүжүүлж байх арга замыг олох шаардлага бий. Энэ нь хөтөлбөрийн тогтвортой хөгжлийг хангах нэгэн үндэс мөн.

Зөвлөмж:

- Математикийн хөтөлбөрийн онцлогийг тооцсон санхүү, дэмжлэгийн эх үүсвэрийг бий болгох. Математикийн хөтөлбөрөөр суралцагчдад Засгийн газрын бүрэн тэтгэлэг олгох саналыг тавьж шийдвэрлүүлэх боломж бий.

3-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

ШАЛГУУР 4. СУРАЛЦАГЧИД ЧИГЛЭСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Тухайн хөтөлбөрөөр суралцагчдын оролцоог ханган бие даан амжилттай суралцахад чиглэсэн дэмжих үйл ажиллагааг хүртээмжтэй, ашиг сонирхолд нь нийцүүлэн үр дүнтэй хэрэгжүүлдэг байна.

4.1 Суралцагч сонгох, элсүүлэх

Хөтөлбөрийн онцлогт тохирсон шалгуураар элсэгчдийг сонгон шалгаруулдаг байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Суралцагч элсүүлэх эрх зүйн зохицуулалтад хөтөлбөрийн онцлогт нийцсэн шалгуурыг тусгасан байдал
- Элсэгчдийн ЕШ-ийн дундаж оноо, хүсэлт гаргасан болон элссэн суралцагчдын харьцаа
- Шинээр элссэн суралцагчдыг чиглүүлэх сургалтад хамруулж, мэдээлэл, гарын авлагаар хангасан байдал

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

- Элсэгчийн онцлогт нийцүүлсэн бодлого хэрэгжүүлдэг. Математикийн олимпиад амжилттай оролцогчдыг татах бодлого зохицуулалт бий. Элсэгчийн ЭЕШ онооны дундаж 2016 оны байдлаар 631 байна. Шинээр элсэгчдэд хандсан мэдээллийн гарын авлага гардаг.

Зөвлөмж:

- Математикийн бакалаврын хөтөлбөрт гадаад улсаас оюутан элсүүлэх боломж бий. Гадаад хэлээр хичээл, сургалт явуулах хүний чадвар, нөөц байгааг ашиглавал зохино.

4.2 Зөвлөн туслах үйлчилгээ

Суралцагчдад суралцах, судлах арга зүй, ирээдүйн ажил мэргэжил, хөдөлмөр эрхлэлт, сэтгэл зүй, хууль эрх зүйн чиглэлээр зөвлөх үйлчилгээг тогмол, чанартай үзүүлдэг байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Зөвлөх, хөгжүүлэх үйлчилгээний төлөвлөгөө, график, үрдүн
- Зөвлөх багш, сургалтын туслах ажилтан, сургалтын менежер, арга зүйч, байрны багш, эмч, сэтгэл зүйч нарын үйлчилгээний чанарын үнэлгээ, сайжруулалт
- Бие хүний төлөвшил, харилцаа, ёс зүйн /зан үйл, зөрчил шийдвэрлэх, эрүүл аж төрөх г.м/ чиглэлүүдээр сургалт явуулж, ур чадвар олгодог байдал
- Суралцагчийн гүйцэтгэсэн сайн дурын ажлыг үнэлдэг байдал
- Суралцагч, төгсөгчдөд хөдөлмөрийн биржийн үйлчилгээ үзүүлдэг байдал
- Суралцагчийн судалгаа, шинжилгээний үйл ажиллагааг дэмжин тусласан байдал

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

- Өөрийн үнэлгээнд дурдсан баримт, үндэслэл нь шинжээчийн ажиглалтаар нотлогдсон. Хөтөлбөрөөр суралцах оюутны тоо харьцангуй цөөн байгаа нь оюутанд хандсан үйлчилгээ хүртээмжтэй, чанартай явагдах бодит нэгэн нөхцөл болж байна.

4.3 Оюутны байгууллагад үзүүлэх дэмжлэг

Оюутны байгууллагаас санаачилсан нийгэмд үзүүлэх үйлчилгээг дэмжин хамтран ажилладаг байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Оюутны сайн дурын үйл ажиллагааг удирдлага, зохион байгуулалтаар хангаж, дэмжсэн байдал
- Оюутны байгууллагын үйл ажиллагааг явуулах төсөв, клубын үйл ажиллагааг дэмжих санхүүжилттэй байх, зориулалтын дагуу зарцуулдаг байдаг
- Оюутны байгууллагын зүгээс санхүүгийн зарцуулалтаа ил тод тайлагнадаг байдал

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

4.4 Суралцагчийн урамшууллын тогтолцоо

Суралцагчдын амжилтыг хөхүүлэн дэмжих урамшууллын системтэй байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Урамшуулал, тэтгэлэгхөнгөлөлтөдхамрагдсансуралцагчдынтоо
- Суралцагчдынүзүүлсэнамжилтууд
- Сургуулиас үзүүлж буй урамшуулал, дэмжлэг

Шалгуурыг хангасан байдал:

- “Математик” хөтөлбөрт хамрагдсан нийт 8 оюутан 2014-2018 оны хугацаанд тэтгэлэгт хамрагдсан байна. Оюутныг тэтгэлэгт хамруулах болон клубийн тогтолцоогоор дэмжих бодлого байна.

4.5 Суралцагчийн шилжилт, хөдөлгөөн

Суралцагчийн шилжилт хөдөлгөөнийг шийдвэрлэхдээ /кредитийг хүлээн зөвшөөрөх, дүйцүүлэн тооцох, кредитээс чөлөөлөх/ холбогдох дүрэм, журмын дагуу суралцагчийн эрх ашигт нь нийцүүлэн шийдвэрлэдэг байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Суралцагчийн шилжилт хөдөлгөөнийг шийдвэрлэсэн байдал
- Шилжилт хөдөлгөөний судалгаа, дүгнэлт
- Шилжилт хөдөлгөөнийг зохицуулж буй дүрэм, журам, гэрээний хэрэгжилт, суралцагчийн эрх ашгийг дээдэлсэн байдал

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

- Оюутны шилжилт, хөдөлгөөний холбогдох зохицуулалт бүрэн хийгдсэн байна.

4-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

ШАЛГУУР 5. БАГШИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Багшийн үйл ажиллагаа нь хөтөлбөрийн үр дүнг амжилттай хэрэгжүүлж, хөгжүүлэхэд чиглэсэн байна.

5.1 Багшийн сонгон шалгаруулалт, албан тушаал, урамшууллын бодлого

Хөтөлбөр нь тавьсан зорилго, зорилтоо хангахуйц онол дадлагыг зохистой хэмжээнд эзэмшсэн эрдмийн зэрэг цолтой, сургалтын арга зүйн өндөр ур чадвартай, мэргэжлийн туршлага бүхий багшийн нөөцтэй байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Хөтөлбөрийн хүний нөөцийн цогц бодлого: тушаал, урамшууллын бодлого сонгон шалгаруулалт, хөгжүүлэлт, төлөвлөлт, хэрэгжилт
- Доктор зэрэгтэй багш нарын эзлэх хувийн жин
- Багш суралцагчдын тооны зохистой харьцаа
- Багшийн албан тушаалын зэрэглэлийн ангилалд тавигдах шаардлагыг мөрддөг байдал
- Гүйцэтгэлийн болон чанарын үнэлгээнд суурилан багш нарыг урамшуулдаг байдал

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

- Математикийн бакалаврын зэргийн сургалтын мэргэжлийн хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлэх чадварлаг хүний нөөц бий болсон. Нийт багш нарын 80 дээш гаруй хувь нь докторын зэрэгтэй. Гадаад хэлтэй.

Онцлог зүйл/Туршлага: Математикийн бакалаврын зэрэг олгох сургалтын хөтөлбөрийг англи хэлээр хэрэгжүүлэх бодит боломж бий.

Анхаарах зүйл: Монгол төдийгүй Англи хэлээр энэ хөтөлбөрийг хэрэгжүүлэх боломж байна. Ингэхэд элсэгчийн хүрээ тэлнэ. Харьцангуй хялбар өртөгөөр математикийн бакалаврын зэргийг чанартай эзэмшүүлэх утгаар дэлхийн зах зээл дээр өрсөлдөх боломж бий. Үүнийг хэрэгжүүлэх хүний чадварлаг нөөц байгааг анхаарч менежментийг хийвэл зохино.

Зөвлөмж: Математикийн бакалаврын зэрэг олгох сургалтын энэхүү хөтөлбөрийг монгол хийгээд англи хэлээр хэрэгжүүлж, гадаад улсаас оюутан элсүүлэх замаар зах зээлийн хүрээг тэлж өргөтгөвөл зохино.

5.2 Багшийн хөгжил

Мэргэжлийн болон сургалт, эрдэм шинжилгээний мэдлэг, арга барил, ур чадвараа тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн багшийн хөгжлийн хөтөлбөртэй байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Багшийн мэргэжил; заах арга зүйн ур чадвар; эрдэм шинжилгээ, судалгааны арга зүйн түвшин; суралцах хэрэгцээг тодорхойлох судалгааг тогтмол хийдэг байдал
- Багшийн хөгжлийн хөтөлбөр, хэрэгжилт, дүн шинжилгээ, сайжруулалт
- Багшийг үе шаттай хөгжүүлж, урт богино хугацаанд мэргэжил, ур чадварыг нь дээшлүүлж чадавхжуулдаг байдал
- Гадаад, дотоодод туршлага судлуулсан байдал

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

- Багш нарыг гадаад, дотоодын эрдэм шинжилгээний хурал, семинар оролцуулах, илтгэл хэлэлцүүлэх, их семинарт илтгүүлэх байдлаар үйл явцаар тогтмол мэргэжлийг дээшлүүлдэг. Мэргэжлийн гадаадын сэтгүүлийг захиалдаг. Энэ бүхний санхүү эх үүсвэрийн зохицуулалтыг хийсэн байна.

5.3 Эрдэм шинжилгээ, судалгаа

Багш эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг тогтмол хийж, судалгааны үр дүн нь хөтөлбөр хэрэгжүүлэхэд үр нөлөөтэй байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Боловсролын болон шинжлэх ухааны шинэ туршилт, инноваци, патентийн тоо
- Захиалгат төсөл, гэрээт ажилд оролцсон байдал
- Судалгааны ажлын үр дүнгээр хөтөлбөрийн сургалтын агуулга, арга зүй; судалгааны ажил шинэчлэгдэн хөгжсөн байдал
- Үндэсний болон олон улсын нэр хүндтэй хэвлэлд нийтлэгдсэн бүтээл, судалгааны ажил, эшлэгдсэн байдал

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

- Математикийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр ажиллаж байгаа багш нарын эрдэм шинжилгээ, судалгааны ажил тогтмолжсон. Тэд гадаад, дотоодын захиалгат болон гэрээт ажилд тогтмол оролцдог. Бүтээл нь үндэсний болон олон улсын нэр хүндтэй хэвлэлд нийтлэгддэг.

5.4 Багшийн үнэлгээ

Багшийн сургалт, заах арга зүй, эрдэм шинжилгээ, судалгаа, мэргэжлийн болон нийгмийн үйлчилгээний /зөвлөх үйлчилгээ/ чиглэлээр хичээлийн жил тутам өөрийн болон хөндлөнгийн үнэлгээг тогтмол гүйцэтгэж, үр дүнг тооцдог байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Өөрийн үнэлгээний тайлан
- Багшийн хөндлөнгийн үнэлгээ /Аттестатчлал, эрэмблэлт, чансаа тогтоолт/
- Сургалтад ашиглаж буй сургах/заах аргын үр дүн, үр нөлөөний судалгаа
- Тайлан, судалгааг хэлэлцэж, дүгнэлт гаргасан байдал
- Сургалтад оролцогчдоор багшийг үнэлүүлэх
- Багшийн бүхий л үйл ажиллагааны баримт, материал

Шалгуурыг хангасан байдал:

- Багш нарыг гүйцэтгэлээр урамшуулдаг тогтолцоо бий болсон. Мөн гүйцэтгэлийг нь бодитой хэмжин үнэлэх механизм бий болсон байна.

5-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

ШАЛГУУР 6. СУРГАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Сургалтын үйл ажиллагаа нь сургуулийн эрхэм зорилгод нийцэж, хөтөлбөрийн үр дүнд чиглэсэн, цогц чадамжид суурилсан, агуулга, арга зүй нь тасралтгүй хөгжин сайжирдаг байна.

6.1 Хөтөлбөрийн сургалтын агуулга, түүний шинэчлэл

Сургалтын агуулга нь суралцагчийн эзэмших цогц чадамжийг олгоход чиглэсэн, онол практикийн зохистой харьцаатай, давхардалгүй, харилцан уялдаатай, сонгох боломжтой, тасралтгүй хөгждөг байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Оролцогч болон сонирхогч талуудын эрэлт хэрэгцээ байгууллагын харьцуулсан шинжилгээ
- Сургалтын агуулга нь хөтөлбөрийн хүрэх үр дүнтэй нийцсэн байдал
- Суралцагч хичээл, багшийг сонгон суралцдаг байдал чиглэсэн, онол практикийн зохистой харьцаатай, давхардалгүй, харилцан уялдаатай, сонгох боломжтой, тасралтгүй хөгждөг байна.
- Хөтөлбөр дэх хичээлийн хэлбэр, онол, практикийн зохистой харьцааг хангасан байдал
- Үйлдвэрлэл, практик, клиник сургалтын агуулгыг хамтран хэрэгжүүлдэг байдал
- Зайны болон цахим хичээлүүдийг E-контент түвшинд боловсруулан сургалтад ашигласан байдал
- Хичээл хоорондын уялдаа, залгамж холбоог хангасан байдал

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

- Сургалтын төлөвлөгөөний хичээлүүд математикийн бакалаврын зэргийн энэхүү хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд бүхэлдээ чиглэсэн хоорондоо учир шалтгааны уялдаа холбоотой, тогтолцоотойгоор хийгдсэн. Хичээлийн онол, практикийн агуулга, судлах цагийн харьцааны нийцэл, зохицол нь олон жилийн бодит үйл ажиллагаа, туршилтаар тогтоогдсон. Сургалтын төлөвлөгөө нь хичээлийг олон хэлбэрээр хувилбартайгаар сонгон суралцах боломжийг өөртөө шингээсэн байна. Багш бүр өөрийн удирдан явуулдаг хичээлийн үндсэн агуулгыг цаасан болон цахим хэлбэрээр мөн боловсруулж бэлтгэн холбогдох хэсгийг цахим хичээл хэлбэрээр байршуулсан байна.

Зөвлөмж:

- Цахим хичээл, цахим хэлбэрт агуулгыг бэлтгэн нийлүүлэхэд багшийн оюуны өмчид халдах, багшийн академик эрх чөлөөг хязгаарлах, академик ёс зүй, соёлын хэм хэмжээг зөрчих үзэгдэл зарим их дээд сургуульд түгээмэл байдаг. Ийм байдлаас зайлсхийхийн тулд энэ хөтөлбөрийн хувьд холбогдох зохицуулалтыг эртнээс хийвэл зохино.

6.2 Сургалтын арга зүй

Сургалтын арга зүй нь хөтөлбөрийн зорилгод нийцсэн, цогц чадамжид суурилсан, суралцагч төвтэй, мэдээлэл, харилцаа холбооны дэвшилтэт технологи ашигладаг байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Сургалтын аргазүйг боловсруулсан баримт бичиг, загвар
- Сургалтад ашиглаж буй арга зүй нь мэдлэг бүтээлгэж, хэрэглэж сургахад чиглэсэн байдал
- Сургалтад хэрэглэж буй мэдээлэл, харилцаа холбооны дэвшилтэт технологи, программ хангамж, техник хэрэгслийн ашиглалтын судалгаа
- Сургалтын арга зүйн судалгаа, дүгнэлт, хөгжүүлдэг байдал

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

- Математикт суралцах, мэргэжих, мэргэших үйлийн өвөрмөц онцлогийг харгалзан олон жилийн бодит туршилтаар нийцэл нь нотлогдсон хичээл, сургалтын тогтсон арга зүй, технологийг бий болгосон байна. Энэ нь өөрийн үнэлгээ болон шинжээчийн ажиглалтаар нотлогдсон.

6.3 Суралцагчийн үнэлгээ

Суралцагчийн эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлагыг бүрэн дүүрэн, үнэлдэг арга зүйтэй, түүнийг байнга сайжруулдаг байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Мэдлэг, ур чадвар, хандлагын түвшин тогтоох, ахиц дэвшлийг үнэлэх үнэлгээний арга, аргачлал, хэрэглээ
- Сургалтын төлөвлөгөөнд тусгагдсан хичээл нэг бүрийн үнэлгээний арга, хэлбэр нь суралцагчдыг тасралтгүй хөгжихөд хөтөлдөг байдал
- Суралцагчийн үнэлгээ нь ил тод, найдвартай, шударга, ижил тэгш зарчмыг хангасан байдал
- Суралцагчийн гаргаж буй амжилтууд

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

- Оюутны үнэлгээний агуулга, хэлбэр, зохицуулалтад ил тод, найдвартай, шударга, ижил тэгш зарчим тусгагдсан. Ихэнхи тохиолдолд оюутныг бодит гүйцэтгэлээр үнэлэх, өөрөөр хэлбэл, гүйцэтгэлд суурилсан үнэлгээний хэлбэр ашиглагдаж байна. Энэ нь математикт суралцах, мэргэжих үйлийн онцлогийг тооцсон үнэлгээний туршигдсан арга хэлбэр бий болсон байна.

6-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

ШАЛГУУР 7. ХӨТӨЛБӨРИЙН ҮР ДҮН, ҮР НӨЛӨӨ

Хөтөлбөрийн үр дүн нь сургуулийн эрхэм зорилго, зорилтыг хангаж, сонирхогч талуудын эрэлтэд нийцсэн, үнэ цэнэтэй байна.

7.1. Хөтөлбөрийн үр дүн

Хөтөлбөрөөр төгсөгч нь сонирхогч талуудын эрэлт хэрэгцээг хангасан, улс орны болон салбарын ирээдүйн тогтвортой хөгжилд хувь нэмрээ оруулан сэтгэл ханамжтай ажиллаж, амьдрах цогц чадамжтай байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Төгсөгчдийн ажил эрхлэлтийн судалгаа, ажлын байрны нийцлийн судалгааг тогтмол явуулж, хөтөлбөрийн шинэчлэлд тусгаж хэрэгжүүлдэг байдал
- Төгсөгчид, ажил олгогчдын сэтгэл ханамжийн судалгаа
- Төгсөгчид ажлын байраар хангагдах хүртлээ хүлээхэд зарцуулах дундаж хугацаа

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

- Математикийн бакалаврын зэргийн хөтөлбөрөөр төгссөн төгсөгчдөд энэ хөтөлбөрт хамрагдан суралцаж зэрэг эзэмшсэндээ сэтгэл хангалуун байдаг. Ихэнхи нь төгссөний дараа богино хугацаанд ажлын байр олдог.

Зөвлөмж:

- Төгсөгчдөд олгодог барим бичигт мэргэжлийн нэрийг тодорхой бичдэг болох. Энэ хөтөлбөрөөр суралцагчдын эзэмших мэргэжлийг тодорхой болгож, индексжүүлэх.

7.2.Хөтөлбөрийн үр нөлөө:

Хөтөлбөр үр дүнгээ үнэлүүлэх, үнэ цэнээ тодорхойлох, ахиц дэвшлээ харуулах нотолгоотой байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Хөтөлбөрөөр төгсөгчдийн амжилтууд
- Салбар, хөдөлмөрийн зах зээлд эзлэх байр суурь
- Мэргэжлийн салбарын хөгжилд оруулсан хувь нэмэр /Төрийн болон ТББ-ын зүгээс хийсэн үнэлгээ, судалгаа/

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

- Төгсөгчдөд боловсрол, шинжлэх ухаан, банк санхүү, бизнес зэрэг нийгмийн янз бүрийн салбарт ажил эрхэлж нийгмийн хөгжилд хувь нэмэр оруулж байна. Ажил олгогчид төгсөгчийн мэргэжлийн чадвар хийгээд хувь хүний хөгжлийн түвшин, байдалд нь сэтгэл хангалуун байдаг.

7.3. Үндэсний болон олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдөх

Үндэсний болон олон улсын хэмжээнд хөндлөнгийн үнэлгээ, магадлан итгэмжлэл хийлгэн суралцагчдын цогц чадамжийг хүлээн зөвшөөрүүлж, олон улсын түвшинд суралцах боломжийг нэмэгдүүлдэг байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Суралцаж буй гадаад оюутны тоо
- Олон улсын хамтарсан хөтөлбөрийн хэрэгжилт
- Улсын болон олон улсын чанартай олимпиад, уралдаан тэмцээнд үзүүлсэн амжилт
- Олон улсад магадлан итгэмжлэгдсэн дараагийн шатны хөтөлбөрт үргэлжлүүлэн суралцаж буй төгсөгчдийн хувь

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

- Математикийн бакалаврын зэргийн хөтөлбөрөөр суралцагч нь үндэсний болон олон улсын түвшний олимпиад, уралдаан тэмцээнд амжилттай оролцож, амжилт үзүүлдэг. Төгсөгчийн ихэнх нь дараагийн шатны сургалтад үргэлжлүүлэн суралцах хандлагатай байдаг.

Зөвлөмж:

- Математик бакалаврын зэргийн хөтөлбөрийг гадаадын их сургуультай хослуулж хамтран хэрэгжүүлэх замаар гадаад оюутны тоог нэмэгдүүлэх боломж байгааг анхаарвал зохино.

7.4. Хөтөлбөрийн нээлттэй, ил тод байдал

Хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгж нь өөрийн үйл ажиллагааны талаар олон нийтэд үнэн зөв, ил тод, дэлгэрэнгүй, сүүлийн үеийн мэдээллийг түгээдэг байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Хөтөлбөрийн үйл ажиллагааны талаар олон нийтийг үнэн зөв, ил тод, дэлгэрэнгүй, сүүлийн үеийн мэдээллээр тогтмол хангадаг байдал
- Вебсайтын мэдээллийн иж бүрэн байдал, тогтмол ажиллагаа

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

- МУИС-ийн цахим хуудасны үйл ажиллагаа тогтмолжсон. Мөн сонирхолын бүлгийн цахим хуудсаар дамжуулан холбогдох мэдээллийг хүргэдэг. Хөтөлбөрийн хэрэгжилттэй холбогдох мэдээллийн ил тод байдал хангагдсан.

7-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

ШАЛГУУР 8. ЧАНАРЫН ҮНЭЛГЭЭ, БАТАЛГААЖИЛТ

Хөтөлбөрийг тасралтгүй хөгжүүлэхэд чиглэгдсэн дотоод чанарын баталгаажуулалтын механизмтай, хөндлөнгөөс үнэлүүлдэг байна.

8.1. Хөтөлбөрийн хяналт, шинжилгээ, үнэлгээг тогтмол, давтамжтай хийдэг байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Хөтөлбөрийн дотоод чанарын баталгаажуултыг хангах удирдлага, зохион байгуулалтын шийдэл, үр дүн
- Дотоод чанарын баталгаажуулалтын тогтсон бодлого, хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилт, үнэлгээ
- Дотоод чанарын баталгаажуулалтад хөтөлбөрийн оролцогч болон сонирхогч талуудын оролцоо
- Хөтөлбөр төлөвлөсөн үр дүндээ хүрч чадсан эсэхийг мэдээ баримтад тулгуурлан дүгнэж өөрийн үнэлгээг хийдэг байдал
- Хөтөлбөрийг шинэчлэн сайжруулах зорилгоор судалгааны үр дүнг хөтөлбөрийн ахиц, дэвшилд системтэйгээр ашигласан байдал
- Хөтөлбөрт орсон өөрчлөлтүүдийн үр нөлөөг хянасан байдал
- Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтэнд эргэх холбоо үүсгэх

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

- Хөтөлбөрийг хөгжүүлэх үйл явцад багш нарын оролцоог хөтөлбөрийн хороогоор дамжуулан хангадаг. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх, сайжруулах, улмаар сургалтын төлөвлөгөөний хичээлийн хөтөлбөр, стандартыг байнга сайжруулах ажил үүрэгжсэн, бүтэцжсэн байна. Үүгээр хөтөлбөрийн чанарыг цаашид “доороос дээш” хандлагаар бодитойгоор чанаржуулах үндэс нөхцөл бүрдэж байна.

8-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шинжээчийн дүгнэлт:

Шалгуур		Бүрэн хангасан (2)	Хэсэгчлэн хангасан (1)	Хангаагүй (0)
1	Хөтөлбөрийн төлөвлөлт	2		
2	Хөтөлбөрийг хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл	2		
3	Хөтөлбөрийн удирдлага, зохион	2		
4	Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа	2		
5	Багшийн үйл ажиллагаа	2		
6	Сургалтын үйл ажиллагаа	2		
7	Хөтөлбөрийн үр дүн, нөлөө	2		
8	Чанарын үнэлгээ баталгаажилт	2		
Нийт		16		

ШИНЖЭЭЧИЙН БАГИЙН ЭЦСИЙН ДҮГНЭЛТ:

Баримт материал, нотлох баримт, уулзалт ярилцлага дээр үндэслэн шинжээчийн баг МУИС-ийн Шинжлэх Ухааны сургуулийн Байгалийн ухааны салбарын “Математик” мэргэжлийн бакалаврын сургалтын хөтөлбөрийг БМИҮЗ-ийн сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн ерөнхий шалгуур шаардлагад нийцэж байгаа тул **“ШАЛГУУРЫГ БҮРЭН ХАНГАСАН”** гэж дүгнэж байна. Шинжээчийн багийн дүгнэлтийг математикийн бакалаврын зэргийн хөтөлбөрийн үнэлгээ хийх мэргэжлийн зөвлөлд хүргүүлж байна.

Шинжээчийн багийн ахлагчийн нэр, гарын үсэг/Ц.Лувсандорж/

Шинжээчийн багийн гишүүний нэр, гарын үсэг..... /Ч.Наранчимэг/

Шинжээчийн багийн гишүүний нэр, гарын үсэг...../Б.Баясгалан/

**Монгол улсын их сургуулийн Шинжлэх ухааны сургуулийн
“Математик” D054101 сургалтын хөтөлбөр
Сургууль дээр ажиллах төлөвлөгөө**

Огноо: 2018-05-23 Лхагва гараг 09.00-18.00 цаг
2018-05-24 Пүрэв гараг 09.00-18.00 цаг

Хугацаа	Үйл ажиллагаа	Хариуцах эзэн
2018-05- 23 Лхагва гараг		
09:00-10:30	Шинжээчийн багийг танилцуулна.	Зохицуулагч
	Шинжээчийн багийн ахлагч үг хэлнэ. - Магадлан итгэмжлэлийн үйл явц, хуваарийг танилцуулах	Шинжээчийн багийн ахлагч
	Сургуулийн захирал үг хэлнэ	Өөрийн үнэлгээний багийн ахлагч
	Удирдлага болон Өөрийн үнэлгээний багтай уулзах: - Удирлагын бэлдсэн хөтөлбөрийн товч танилцуулга /тайлан бичсэнээс хойшхи мэдээллийг оруулах/	Өөрийн үнэлгээний багийн ахлагч
10:30-12:00	Сургуулийн бэлтгэсэн материал, илрэл нотолгоотой шинжээчид танилцана	Шинжээчид
12:00-13:00	Сургуультай танилцах	Шинжээчид
13:00-14:00	Өдрийн хоол	
14:00-15:00	Оюутнуудтай хийх уулзалт	Шинжээчид
15:00-16:00	Багш нартай хийх уулзалт	Шинжээчид
16:00-17:00	Номын сан болон лаборатори, үйлчилгээний хэсэгтэй танилцана	Шинжээчид
17:00-18:00	Өөрийн үнэлгээний тайлангийн нотлох баримттай танилцах	Шинжээчид
2018-05- 24 Пүрэв гараг		
09:00-10:00	Тайлантай холбоотой нотлох баримттай танилцах, холбогдох хүмүүсээс тодруулга, лавлагаа авах	Шинжээчид
10:00-11:00	Ажил олгогчидтой хийх уулзалт	
11:00-11:10	Завсарлага	
11:10-12:10	Төгсөгчидтэй хийх уулзалт	
12:10-13:10	Өдрийн хоол	
13:10-15:30	Тайлантай холбоотой нотлох баримттай танилцах, холбогдох хүмүүсээс тодруулга, лавлагаа авах Шинжээчдийн багийн уулзалт	
15:30-17:00	Тайлантай холбоотой нотлох баримттай танилцах, холбогдох хүмүүсээс тодруулга, лавлагаа авах Шинжээчдийн багийн уулзалт	
17:00-18:00	Шинжээчдийн баг магадлан итгэмжлэлийн эцсийн шийдвэрийг бус, урьдчилсан дүгнэлтийг байгууллагад мэдэгдэнэ.	

II. Ярилцлагад оролцсон оролцогчдын жагсаалт
1. Багш нарын нэрс

МУИС-ийн ШУС-ийн БУС-ын Математикийн тэнхимийн
багш нарын нэрс

2018-05-23

№	Багш, ажилтны нэрс		Тархи үсэг
1	С.Төмөрбат		
3	В.Адъяасүрэн		
4	Л.Хадхүү		
5	Д.Пүрэвсүрэн		
6	Ц.Гантулга		
7	Ц.Сэлэнгэ		
8	Ж.Даваадулам		
9	Ү.Отгонбаяр		
10	Б.Баяржаргал		
11	Н.Ууганбаатар		
12	Д.Түмэнбаяр		
13	Ц.Батболд		
14	А.Булган		
15	Ц.Навчаа		
16	Т.Хулан		
17	Д.Даянцолмон		
18	З.Ууганбаяр		
19	А.Амарзаяа		

-?

2. Төгсөгчдийн нэрс






Төгсөгчид

№	Овог нэрс	Ажлын газар	Албан тушаал	Гарын үсэг
1	Г.Түмэндэмбэрэл	ШМТДС	Багш	<i>Г.Түмэндэмбэрэл</i>
2	Б.Жигжиддорж	Kings Kids	Багш	<i>Б.Жигжиддорж</i>
3	Т.Базар	Математикийн хүрээлэн	ЭША	<i>Т.Базар</i>
4	Лхагвахатан	Шинэ монгол	Багш	<i>Лхагвахатан</i>
5	Б.Янжинлхам	IT zone	<i>А.Т. мэргэжилтэн</i>	<i>Б.Янжинлхам</i>
6	О.Мандухай	<i>ЧБ-ийн БАС</i>	<i>багш</i>	<i>О.Мандухай</i>
7	Энхбаатар	11 сургууль	Багш	<i>Энхбаатар</i>
8	Ц. Тайвансайхан	ШМТДС	Багш	<i>Ц.Тайвансайхан</i>
9	С.Оюунхүү	<i>Абсолют Элт.</i>	Багш	<i>С.Оюунхүү</i>
10	Ш.Энхтуяа	<i>ОАЭИС</i>	<i>мэргэжилтэн</i>	<i>Ш.Энхтуяа</i>
11	Халиун	ЭМДаатгалын хэлтэс		
12	Бямбаноров	<i>ДМД</i> Монгол ХХК	<i>Мэргэжилтэн</i>	<i>Б.Бямбаноров</i>
13	Б.Ганбат	Логарифм	Багш	<i>Б.Ганбат</i>

~~12~~
 14. *Б.Зайсан* *Кемптон* *Менеджер* *Б.Зайсан*

3. Ажил олгогчдын нэрс

Ажил олгогч

№	Овог нэрс	Ажлын газар	Албан тушаал	Гарын үсэг
1	Ү.Отгонбаяр	Математикийн хүрээлэн	Математикийн хүрээлэнгийн захирал	
2	А. Энхжаргал	Эхлэл сургууль	Захирал	
3	Д.Өлзийжаргал	Хаан банк	Зээлийн үйл ажиллагааны захирал	
4	Д.Энхжаргал	11 сургууль	Захирал	
5	Б.Эрдэнэбат	1 сургууль	Сургалтын менежер	
6	Ш.Буянжаргал	Шинэ Монгол, Коосэн	Захирал	
7	Эрдэнэжаргал	IT zone	Хүний нөөцийн албаны дарга	

4. Оюутны нэрс:

5 сарын 23-ны өдөр 14-15 цагийн хооронд уулзах

№	Оюутны нэрс	Курс	Сонгосон байдал	Утас	Гарын үсэг
1	С.Дэлгэр	4	Дотуур байранд амьдардаг	99555405	<i>[Signature]</i>
2	Э.Оргил-Эрдэнэ	4	Голч 3.8	93399550	<i>[Signature]</i>
3	Л.Сарантунгалаг	4	Хотынх	99284339	<i>[Signature]</i>
4	Т.Ундармаа	4	Ангийн дарга	80008794	<i>[Signature]</i>
5	Б.Хишигжаргал	4	Хөдөө орон нутгийнх	88691870	<i>[Signature]</i>
6	С.Батбаяр <i>Ч. Бадмаг</i>	3		86403035	<i>[Signature]</i>
7	Ц.Билэгжаргал	3			
8	А.Нямдаваа	3	Ангийн дарга	99744356	<i>[Signature]</i>
9	Р.Одхүү	3		59502070	<i>[Signature]</i>
10	Б.Эрдэнэбаяр	3	Голч оноо 3.9	96221008	<i>[Signature]</i>
11	Э.Ариунболд <i>Б. Арвансайх</i>	2		89727601	<i>[Signature]</i>
12	Б.Даваадорж	2	Голч оноо 3.5	94645222	<i>[Signature]</i>
13	Ц.Мөнхзул	2		98234234	<i>[Signature]</i>
14	Б.Мянгарсүх <i>Э. Огбоор</i>	2		99008950	<i>[Signature]</i>
15	Г.Амарсанаа	2			
16	А.Шүрэн-Эрдэнэ	2	Ангийн дарга	86560926	<i>[Signature]</i>

Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал



МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
ШИНЖЛЭХ УХААНЫ СУРГУУЛЬ

14201 Улаанбаатар хот-46в ш/х-330, Сүхбаатар дүүрэг,
Бага тойруу 47, Утас/Факс: (976-11) 32-54-35,
E-mail: sas@num.edu.mn, http://sas.num.edu.mn

2018.06.18 № 7af9a8

танай _____-ны № _____-т

БОЛОВСРОЛЫН МАГАДЛАН
ИТГЭМЖЛЭЛИЙН ҮНДЭСНИЙ
ЗӨВЛӨЛД

Математик хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн
шинжээчийн тайланд хариу өгөх тухай

БМИУЗ-ийн Ажлын Албаны захирлын тушаалаар томилогдсон шинжээчийн баг 2018 оны 05 дугаар сарын 23, 24-ний өдрүүдэд МУИС-ийн ШУС-ийн Байгалийн Ухааны Салбарын Математик хөтөлбөрийг магадлан итгэмжлэх шинжээчээр ажиллалаа. Улмаар 2018 оны 06 дугаар сарын 06-нд ирүүлсэн шинжээчийн багийн тайлантай танилцан ихэнх зөвлөмжийг хүлээн авч байгаа бөгөөд цаашид засан сайжруулах талаар санал боловсруулан МУИС-ийн холбогдох удирдлагуудад хүргүүлэх болон төлөвлөгөө гарган ажиллах болно. Үүнтэй зэрэгцэн хөтөлбөрийн үйл ажиллагаанд хэвшсэн, сургалтын журмаар зохицуулагддаг асуудлуудыг зөвлөмжид тусгасан хэд хэдэн шалгуур байна. Үүнд:

1. 1.1 Математикийн тэнхимийн хөтөлбөрийн хороо байнга ажиллан математикийн хөтөлбөрийг сайжруулах ажлыг байнга хийж байна.
2. 2.3 Хөтөлбөрийн ном сурах бичгээр баяжуулах талаар МУИС-ийн холбогдох журмаар зохицуулдаг бөгөөд зөвхөн дотоодын төдийгүй гадаадын сурах бичгээр баяжуулах боломжтой байдаг.
3. 3.1 Либерал арт үзэл санааг МУИС-ийн хэмжээнд хэрэгжүүлж байгаа тул зөвхөн математикийн хөтөлбөрийн хувьд бид тохирч байгаа эсэхэд дүн шинжилгээ хийсний үндсэн дээр холбогдох Хөтөлбөрийн хороодод тодорхой санал тавих болно.
4. 3.6 Байгалийн ухааны салбарын чиглэлээр тэтгэлэгт хөтөлбөрийг сүүлийн жилд МУИС-ийн болон бүрэлдэхүүн сургуулийн зүгээс анхаарал хандуулан ажиллаж байгаа бөгөөд тэтгэлгийн тоо хэмжээг нэмэгдүүлэх талаар Математикийн тэнхим мөн өөрийн хувь нэмрээ оруулан ажиллах болно.
5. 6.1 Зөвлөмжид тусгасан асуудал нь МУИС-ийн хэмжээнд "МУИС-ийн оюуны өмчин талаар баримтлах бодлого", "МУИС-ийн технологи дамжуулах журам"-аар зохицуулагддаг.

Хамтран ажилласан та бүхэнд талархал илэрхийлье.

ХӨТӨЛБӨРИЙН БОДЛОГО,
ДОТООД ЗОХИОН БАЙГУУЛАЛТ,
БАЙГАЛИЙН УХААНЫ
САЛБАР ХАРИУЦСАН
ДЭД ЗАХИРАЛ
ДОКТОР (PhD)



Ц.АМАРТАЙВАН

My.Doc a bich. p.232

Ү. Мэргэжлийн зөвлөлийн шийдвэр

Мэргэжлийн зөвлөлийн хуралдаан (огноо)
[Мэргэжлийн зөвлөлийн хэлэлцүүлгийн дүгнэлт]

Магадлан итгэмжлэхэсэх	Магадлан итгэмжлэл олгоххугацаа

Зөвлөмж/Recommendations/

ҮІ. Магадлан итгэмжлэхкомиссын шийдвэр

Магадлан итгэмжлэх комиссын хуралдаан(огноо)
[Магадлан итгэмжлэх комиссын хэлэлцүүлгийн дүгнэлт]

Магадлан итгэмжлэхэсэх	Магадлан итгэмжлэл олгоххугацаа

Зөвлөмж/Recommendations/